



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

ХОХМЫН ОНЫ 03 САРЫН 03 ЕДӨР

Дугаар 8/25

Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

- “Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-г хавсралтаар баталсугай.
- Батлагдсан төлөвлөгөөний дагуу арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тайлagnаж Авлигатай тэмцэх газарт хүргүүлж ажиллахыг Захиргаа, удирдлага, хамтын ажиллагааны газар /Б.Энхгэрэл/-т даалгасугай.


ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛООН ГҮЙЦЭТГЭГЧ



Ж.БАТСАЙХАН

1523010229

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн
газрын даргын 2023 оны 11 дугаар тушаалын
хавсралт



**ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН 2023 ОНЫ
АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжи хугацаа	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин, үр дүн	Хариуцах нэгж
1	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	АТГ-аас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэх	Жилдээ	-Баримтжуулсан байх -Үр дүнг тооцож, тайлагнасан байх. (түгээсэн тоо, давтамж, авсан хандалтын тоо) -Харьяа газар, нэгжүүдийг хамруулсан байх.	-12 ба дээш мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэсэн байна.	ЗУХАГ, ОЗМТХ
		Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг харьяа байгууллага, салбарын онцлогт тохируулан зохион байгуулах		-Хоёроос доошгүй өдөрлөг, нөлөөллийн үйл ажиллагаа г.м соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан байх; - Үр дүнг тооцож, нотломжийг хавсаргасан байх.	-Мэдээ, мэдээлэл нь олон нийтэд хүрсэн байна.	ЗУХАГ, ГЗБХ, ССМХ, ХБХ, ХБКХ, КХ, ГЗЗХ
		Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчилах "Шударга ёс, хөгжил дэвшилд 110" мэдээллийн самбар ажиллуулах;		- Мэдээллийг сар бүр шинэчлэх; - Тайланд сар бүр шинэчилсэн нотломжийг хавсаргасан байх.	-Мэдээлэл тогтмол шинэчлэгдсэ н байна.	ЗУХАГ

		<p>Өөрсдийн үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий (шторк, зурагт хуудас, сонины нийтлэл, радио контент, цахим, хэвлэмэл ном, гарын авлага, броюшур зэргээс боломжит хэлбэрийг сонгон) сурталчилгааг хийж олон нийтэд хүргэх.</p>	Жилдээ	<p>-Хоёроос доошгүй сурталчилгааны материал боловсруулсан байх; -Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбууκ, твиттер, инстаграм youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх; - Авлигыг мэдээлэх утас 110 дугаарыг дурдсан байх</p>	<p>-Мэдээлэл тогтмол шинэчлэгдсэн байна.</p>	ЗУХАГ, ГЗБХ, ССМХ, ХБХ, ХБКХ, КХ, ГЗЗХ
2	Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, сургалтад хамруулах	Төрийн албанад шинээр томилогдсон албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулах	Жилдээ	<p>- Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо</p>	<p>-Сургалтад хамрагдсан байна.</p>	ЗУХАГ
		<p>Тухайн байгууллагын хариуцдаг, шууд хамаардаг, хамтран ажилладаг (тухайлбал, тусгай зөвшөөрөл эзэмшигч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, хамтран ажилладаг бизнесийн байгууллага, үйлчилгээ авдаг хуулийн этгээд, иргэн, хяналт, оролцоо хэрэгжүүлдэг ТББ г.м) байгууллагад авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний үр дүнг</p>	Жилдээ	<p>-хоёроос доошгүй арга хэмжээг зохион байгуулсан байх</p>	<p>-Зохион байгуулагдаа н байна.</p>	ЗУХАГ, ГЗБХ, ССМХ, ХБХ, ХБКХ, КХ, ГЗЗХ

		мэдээлэх сурталчилах арга хэмжээг зохион байгуулах				
		Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан зохион байгуулах	Жилдээ	- Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	-Сургалтад хамрагдсан байна.	ЗУХАГ
3	Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох	Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах	Тухай бүр	-Байгуулсан бүх гэрээнд авлигаас анgid байх асуудлыг тусгасан байх; -Авлигыг мэдээлэх үүргийг тусгасан байх; -Гэрээг цуцалсан тохиолдолд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг оруулах; -Хэрэгжилтийн ач холбогдлыг үнэлж, дүгнэсэн байх	-Зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.	ЗУХАГ
		"Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ыг хэрэгжүүлэх	Тухай бүр	-Олон нийтийн хяналтад хамруулах чиглэлийг тодорхойлсон байх; -Сургалт, мэдээлэл авсан байх; -Хяналтын чиг үүргийг гүйцэтгүүлэх, тайлан зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлсэн байх	-Нотлох баримт, шинжээчийн дүгнэлтийг хүргүүлсэн байна.	ЗУХАГ
4	Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг эрилгүулах	Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх /үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж,	Жилдээ	-Үйл ажиллагаанд эрсдэлийг тодорхойлж, урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, үр дүнг тооцсон байх; - Тайланд нотломжийг	-Үйлчилгээ цахим болсон байна.	ЗУХАГ, ГЗБХ, ССМХ, ХБХ, ХБКХ, КХ, ГЗЗХ

		асуудлыг шийдвэрлүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх г.м/		хавсаргасан байх		
		Салбарын хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох, хүнд суртлыг бууруулах чиглэлээр хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулж, шалтгаан нөхцөлийг арилгах	Жилдээ	-2-оос доошгүйг зохион байгуулсан байх; -Хэлэлцүүлэг, уулзалтын үр дүнд арга хэмжээ зохион байгуулсан байх; - Тайланд нотломжийг хавсаргасан байх	-Мэдээлэл шинэчлэгдсэн байна.	ЗУХАГ
		Үйлчлүүлэгчдээс авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгааны дүгнэлтэд тулгуурлаж арга хэмжээ зохион байгуулах	Жилдээ	-Бодитой үр дүнг тооцсон байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх	-Мэдээлэл шинэчлэгдсэн байна.	ЗУХАГ
5	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх	Удирдлагын зүгээс 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 1-р улиралд, хэрэгжилтийн явцыг эхний хагас жилд, хэрэгжилт, хүрсэн үр дүнг жилийн эцсээр нийт албан хаагчдадаа танилцуулах	Жилдээ	-Танилцуулах арга хэмжээг зохион байгуулсан байх; Албан хаагчдаас гаргасан санал санаачилгыг хэлэлцсэн байх;	-Албан хаагчдад танилцуулсан байна.	ЗУХАГ
		Авлигатай тэмцэх газраас дүрэм журам, ёс зүйн дүрмийн төсөлд өгсөн санал, зөвлөмжийг тусган ажиллах	Жилдээ	-Санал тусгасан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.	-Санал авсан байна.	Холбогдох нэгжүүд
		Удирдлага салбар, нэгж, байгууллагын хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр санаачлан хийх ажил, арга хэмжээг нэмж төлөвлөн, тайлагнах	Жилдээ	-Төлөвлөгөөг баталж, олон нийт танилцах боломжоор хангасан байх; -khutulbur.iaac.mn цахим санд нэмж оруулсан байх, - тайлагнасан байх.	-Хэрэгжсэн байна.	ЗУХАГ